



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Сахилга, хариуцлага, дэг журмыг
сайжруулах тухай

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчдын сахилга, дэг журмыг чангатгах, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлага, албан хаагчдад:

1.1. "Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, "2018 оныг Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил болгон зарлах тухай" Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, зарцуулсан хөрөнгө, гарсан шийдвэр бүрийн үр дүнг бодитой тооцон, тайлагнаж ажиллах;

1.2. Албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг өндөржүүлж, ажлын байранд архидан согтуурах, албан үүргээ гүйцэтгэж байх үедээ согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, зөрчил гаргасан албан хаагчдад албан тушаал үл харгалзан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах;

1.3. Гал түймэр, үер, газар хөдлөлт, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах зэрэг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж, байгууллагын харуул хамгаалалтыг сайжруулах, иргэд болон албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

1.4. Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж, төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, заавар, зөвлөмжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандартыг мөрдөж ажиллах;


1.5. Иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, байгууллага бүр Ёс зүйн хорооныхоо үйл ажиллагааг идэвхжүүлж, зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага хүлээлгэн, зохих журмын дагуу холбогдох байгууллага, иргэд, ажилтнууддаа мэдээлдэг байх;

1.6. Албан хаагчдын ирцийн бүртгэл, цаг ашиглалт, нийтийг хамарсан ажилд оролцсон байдал, захиргааны чөлөө олголт, эмнэлгийн хуудас, эмчийн магадлагааны үндэслэл зэргийг хянаж, цалингийн тооцоо, ажил дүгнэхэд тооцох.

Хоёр. Энэ албан даалгаврын хэрэгжилтийн тайланг улирал тутам гаргаж, дараа сарын 05-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байхыг холбогдох байгууллагын удирдлагуудад үүрэг болгож байна.

Гурав. Энэ албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн, нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр улирал тутам мэдээлж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгаж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД